

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК-ийн 2018 оны санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: САГ-2019/62/СТА-ТӨҮГ

Агуулга

1	Аудитын гэрчилгээ.....	3
2	Аудитын тайлан	5
2.1.	Оршил	5
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	6
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	7
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	8
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.8.1.	Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээлэл	8
2.8.2	Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал.....	8
2.8.2.1.	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	9
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	9
2.10.	Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	9
2.11.	Шилэн дансны мэдээлэл.....	10
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	10
2.13.	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	10
3	Менежментийн захидал	11
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	14
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	14
4.2	Аудит хийсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан	15
4.3	Аудит хийсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан	16
4.4	Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан	17
4.5	Аудит хийсэн 2018 оны эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшин, төлөвлөгөөний биелэлт	18
4.5.1.	Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин	18
4.5.2.	Зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл.....	19

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

ҮНЭТ ЦААСНЫ ТӨВЛӨРСӨН
ХАДГАЛАМЖИЙН ТӨВ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Ж.БАЙГАЛМАА
ТАНАА

2019.03.15 № 06/456
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК-ийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Аудитын гол асуудал


Үнэт цаас өмчлөгч, харилцагчдын харилцах дансан дахь мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг хадгаламжинд байршуулж хүүгийн орлого олж байгаа нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.7, 45.8 дахь заалт болон санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг батламж мэдэгдэлд нийцээгүй байна.

Үүрэг, хариуцлага

Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

1 Аудитын тайлан

2.1. Оршил

Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК-ийн 2018 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүн, дүгнэлтийг гүйцэтгэх захирал Ж.Байгалмаа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК-ийн 2018 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт гаргах нь энэхүү аудитын зорилт байв.

Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК-ийн удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 11 дүгээр сарын 20-ноос 2019 оны 3 дугаар сарын 10-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 3 дугаар сарын 14-ний өдөр эцэслэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, Юнистар аудит ХХК-ийн ахлах аудитор Б.Тэрбиш ахлагчтай баг хариуцаж хэрэгжүүлэв.

Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК-ийн 2018 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт 2019 оны 2 дугаар сарын 14-ний өдрийн 01/462 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, НББОУС, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК-ийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Үнэт цаасны цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК нь “Үнэт цаасны хадгаламж, өмчлөх эрхийн бүртгэлийн аюулгүй байдлыг ханган, үйл ажиллагаагаа шударга, шуурхай, ил тод явуулан үнэт цаасны зах зээлийг төлөвшүүлэн хөгжүүлэхэд оршино” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээнд тус компанийн үйл ажиллагааны чиглэлийг “үнэт цаасны өмчлөх эрх, үнэт цаасны төвлөрсөн хадгаламж” гэж тодорхойлжээ. Мөн Санхүүгийн зохицуулах хорооны 2017 оны 72 дугаар тогтоолоор тус компанид олгосон тусгай зөвшөөрлийн гэрчилгээнд “үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа”, “үнэт цаасны өмчлөх эрхийн бүртгэлийн үйл ажиллагаа” эрхлэх гэжээ.

Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК-ийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК-ийн удирдлага нь дараах хууль болон Сангийн сайдын баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Үнэт цаасны зах зээлийн тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК-ийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК санхүүгийн тайланг бэлтгэхдээ компанийн дотооддоо боловсруулсан нягтлан бодох бүртгэлийн “СоларСис” програм хангамж ашигладаг байна.

Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК-ийн бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 9 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 7 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн тайлангийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогын 1.0 хувиар сонгов.

Орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь компанийн хувьд санхүүгийн гол үзүүлэлт нь орлого гэж үзсэнтэй холбоотой юм.

Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК-ийн 2018 оны нийт орлого 3,390.7 сая төгрөг бөгөөд түүний 1.0 хувь болох 33,9 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1.0 хувиар тооцсон нь эрсдэл дунд гэж үзсэнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 11 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 4 асуудлыг алдаа, зөрчилтөйд тооцож, 7 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэсэнээс гадна 1 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

2.8.1. Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээлэл

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах асуудлыг залруулга хийлгэн санхүүгийн тайланд тусгаж, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК-ийн удирдлагаар зөвшөөрүүлэн баталгаажуулав. Үүнд:

- Ашиглалтанд тавьж олгосон 16.0 сая төгрөгийн хангамжийн материалыг бараа материалын дансанд үлдэгдлээр бүртгэснийг хуримтлагдсан үр дүнд хааж залруулсан.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

2.8.2 Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй
асуудлыг ангилсан байдал

(сая төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	3	29.9	
	Дүн	3	29.9	

2.8.2.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг менежментийн захидалд оруулсан ба зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудал гараагүй.

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Мэдээллийн системийн болон дүрэм журмын шинэчлэл хийгдэж байгаа тул дараагийн аудитаар өөрчлөлтийн үеийн эрсдэл болон нийцэл, мөн хадгаламж болон хүүгийн орлогод анхаарал хандуулах шаардлагатай.

2.10. Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Компанийн удирдлага нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21¹ дүгээр зүйлд заасны дагуу компанийн жилийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнах үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар байгууллагын удирдлага нь батлагдсан төлөвлөгөө, зорилтот түвшин, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Сангийн сайдын 2018 оны 259 дугаар тушаалаар баталсан Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК-ийн 2018 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинд зааснаар үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 4 хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 1,399.5 сая төгрөгийн нийт зардал батлагджээ. 2018 оны гүйцэтгэлээр 1,286.2 сая төгрөгийн зардал гаргаж, зардлын гүйцэтгэл 92.0 хувиар биелжээ. Төлөвлөгдсөн зардал 113.4 сая төгрөгөөр хэмнэгдсэн нь технологи хөгжүүлэлтийн ажил хойшлогдож 122.9 сая төгрөгийн зардал гараагүй нь нөлөөлжээ. Харин нийт орлогыг 2,639.7 сая төгрөгөөр төлөвлөсөн бол гүйцэтгэлээр 3,718.3 сая төгрөгийн орлого олж орлогын төлөвлөгөөгөө 140.8 хувиар биелүүлсэн байна. Орлогын төлөвлөгөө 1,078.6 сая төгрөгөөр давж биелэхэд үнэт цаасны өмчлөх эрхийн бүртгэлийн орлого 277.6 хувиар, бусад орлого 165.3 хувиар, хүүгийн орлого 104.1 хувиар давж биелсэн нь голлон нөлөөлсөн байна. Татварын дараах цэвэр ашиг 1,137.9 сая төгрөгөөр төлөвлөгдсөн бол гүйцэтгэлээр 2,244.8 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж ашгийн төлөвлөгөөгөө 197.3 хувиар биелүүлжээ. Борлуулалтын 1 төгрөгт

ногдох зардал 0.53 төгрөгөөр төлөвлөгдсөн бол гүйцэтгэлээр 0.35 төгрөг болж зорилтот түвшин биелсэн байна.

Батлагдсан зорилтот түвшингийн биелэлт, орлого, зардлын төлөвлөгөөний биелэлт, зардлын хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 2 зөвлөмж өгсөн ба зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК-ийн 2018 оны санхүүгийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК-ийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тусгасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, стандартад нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

2 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1. Орлогын данстай холбоотой асуудал:

3.1.1. Илрүүлэлт

Үнэт цаас өмчлөгч, харилцагчдын харилцах дансан дахь мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг компанийн нэр дээр хадгаламжинд байршуулж хүүгийн орлого олж байгаа нь санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг батламж мэдэгдэлд нийцээгүйгээс гадна Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.7, 45.8 дахь заалтыг зөрчиж байна.

3.1.2. Эрсдэл

Харилцагчдын хөрөнгийг өмчлөгчийн зөвшөөрөлгүй захиран зарцуулж орлого ашиг олж байгаа нь хууль зөрчигдөх, өмчлөх эрхийн маргаан гарах, улмаар компанийн санхүүгийн байдалд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй.

3.1.3. Өгсөн зөвлөмж

Харилцагч үнэт цаас өмчлөгчдийн харилцах дансан дахь мөнгөн хөрөнгийн менежментийг хийхдээ Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороо зэрэг бодлого, зохицуулалт, удирдлагаар хангадаг дээд байгууллагуудтай зөвлөлдөж, өмчлөгчдийн эрх ашгийг хохироохгүй, хуульд нийцсэн бодлогын шийдэл гаргаж хэрэгжүүлэх, өмчлөх эрхийн маргаан үүсч байгууллагын санхүүгийн чадавхид нөлөөлөх эрсдэлээс сэргийлж, хууль хэрэгжүүлж ажиллах.

3.1.4. Байгууллагаас өгсөн хариу, тайлбар

Зөвлөмжийг хүлээн зөвшөөрч байна. Харилцагчдын харилцах дансан дахь мөнгөн хөрөнгийг банкинд хадгалуулах эсэх талаар 2018 оны 11-р сарын 4-ний өдөр компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд танилцуулсан. Цаашид аудитын зөвлөмжийн дагуу зохих арга хэмжээ авч ажиллана.

3.2. Балансын данстай холбоотой асуудал

3.2.1. Илрүүлэлт

Компанийн дотоод журмын 7.1.1-д “...ажилтанд...захирлуудын зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн...нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд нь зориулж компанийн зүгээс хүүгүй зээл олгож болно” гэж заасан нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 3 дахь заалтыг зөрчсөн байна. Дотоод журмын энэ заалтыг үндэслэн 2018 онд 3 ажилтанд 22.0 сая төгрөгийн зээл олгосон байна.

3.2.2. Эрсдэл

Хууль зөрчигдөх, төрийн өмч хууль бусаар ашиглагдах эрсдэлтэй.

3.2.3. Өгсөн зөвлөмж

Компанийн дотоод журмын 7.1.1 дэх заалтыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 3 дахь заалтад нийцүүлэх.

3.2.4. Байгууллагаас өгсөн хариу, тайлбар

Аудитын зөвлөмжийн дагуу компанийн дотоод журамд өөрчлөлт оруулж, эрх бүхий байгууллагын шийдвэрийн дагуу Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг баримталж ажиллана.

3.3. Зардлын данстай холбоотой асуудал:

3.3.1. Илрүүлэлт

Ажилтан өндөр насны тэтгэвэрт гарах үед Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэргүйгээр гүйцэтгэх захирал тушаал гаргаж 7,9 сая төгрөгийн буцалтгүй тусламж олгосон. Энэ нь компанийн дотоод журмын 7.1.10-д “Компанид хөрөнгийн зах зээл үүссэнээс хойш тогтвор суурьшилтай ажилласан ажилтан нь ... өндөр настны тэтгэвэр тогтоолгоход нэг удаагийн мөнгөн тэтгэмж олгох асуудлыг Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулан шийдвэрлүүлнэ” гэж заасныг зөрчсөн.

3.3.2. Эрсдэл

Хууль, журам зөрчигдөж, төрийн өмч хууль бусаар ашиглагдах эрсдэлтэй.

3.3.3. Өгсөн зөвлөмж

Ажиллагсдад буцалтгүй тусламж дэмжлэг олгохдоо компанийн дотоод журмын заалтыг мөрдөж ажиллах.

3.3.4. Байгууллагаас өгсөн хариу, тайлбар

Захиргаа хууль эрх зүйн албаны жолооч өндөр насны тэтгэвэрт гарсантай холбоотойгоор Гүйцэтгэх захирлын 2018 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн А-29 тушаалын дагуу буцалтгүй тусламж олгосон. Энэ нь компанийн дотоод журмын 7.1.10-д "тус буцалтгүй тусламжийг ТУЗ-өөр шийдвэрлүүлнэ" гэсэн заалтыг зөрчсөн нь үнэн болно. Зөвлөмжийг хүлээн зөвшөөрч байна

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 07 дугаар сарын 01-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

3 Аудит хийсэн санхүүгийн тайлан

3.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан.

Балансын үзүүлэлт	/төгрөгөөр/	
	2018 оны 1-р сарын 1	2018 оны 12-р сарын 31
ХӨРӨНГӨ		
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ		
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	588,396,464.36	2,146,641,544.26
Дансны авлага	11,133,032.41	63,417,831.44
Бусад авлага	162,566,360.79	977,723,363.00
Урьдчилж гарсан зардал	23,947,437.65	26,858,741.22
Бусад санхүүгийн хөрөнгө/	6,191,927,342.22	5,900,000,000.00
Бараа материал	25,794,381.05	14,835,499.60
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>7,003,765,018.48</u>	<u>9,129,476,979.52</u>
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ		
Үндсэн хөрөнгө	1,638,734,561.62	1,541,898,248.74
Биет бус хөрөнгө	14,911,460.51	30,803,476.07
Урт хугацаат хөрөнгө оруулалт	5,758,978,715.12	6,257,422,726.72
Хойшлогдсон татварын хөрөнгө	3,663,057.37	6,565,554.24
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>7,416,287,794.62</u>	<u>7,836,690,005.77</u>
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	<u>14,420,052,813.10</u>	<u>16,966,166,985.29</u>
ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ		
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
Дансны өглөг	5,750,000.00	535,094.32
Татварын өглөг	866,442.85	97,433,705.90
Урьдчилж орсон орлого	3,416,067.09	10,794,974.45
Бусад өглөг	10,386,392,628.31	10,678,707,257.44
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	<u>10,396,425,138.25</u>	<u>10,787,471,032.11</u>
УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
Нөөц /өр төлбөр/	100,000,000.00	100,000,000.00
УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	100,000,000.00	100,000,000.00
НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>10,496,425,138.25</u>	<u>10,887,471,032.11</u>
ЭЗДИЙН ӨМЧ		
Өмч: - төрийн	3,000,000,000.00	3,000,000,000.00
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	98,723,938.00	98,723,938.00
Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг		26,624,000.00
Хуримтлагдсан үр дүн	921,240,679.48	2,953,348,015.18
ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	<u>3,923,627,674.85</u>	<u>6,078,695,953.18</u>
ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧИЙН ДҮН	<u>14,420,052,813.10</u>	<u>16,966,166,985.29</u>

3.2 Аудит хийсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан.
/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
Борлуулалтын орлого(цэвэр)	694,275,099.19	1,848,644,211.18
Борлуулалтын өртөг	277,379,490.06	327,627,915.88
Нийт ашиг	416,895,609.13	1,521,016,295.30
Хүүгийн орлого	1,241,948,718.97	1,784,951,560.71
Бусад орлого	3,463,091.01	84,629,949.05
Ерөнхий ба удирдлагын зардал	736,160,839.42	940,635,304.28
Бусад зардал	13,684,615.35	17,909,017.08
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-769,595.08	100,988.28
Бусад ашиг (алдагдал)	-62,131.00	
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	911,630,238.26	2,432,154,471.98
Орлогын татварын зардал	14,217,137.57	187,286,775.07
Татварын дараах ашиг алдагдал	897,413,100.69	2,244,867,696.91
Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал	897,413,100.69	2,244,867,696.91

3.3 Аудит хийсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан.
/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,000,000,000.00			34,039,398.79	2,034,039,398.79
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,000,000,000.00	0.00		34,039,398.79	2,034,039,398.79
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт		98,723,938.00			98,723,938.00
Эзэмшигчдийн өмчид гарсан өөрчлөлт	1,000,000,000.00			-100,000,000.00	900,000,000.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				3,663,000.00	3,663,000.00
Зарласан ногдол ашиг				-10,211,762.63	-10,211,762.63
Тайлант үеийн үр дүн				897,413,100.69	897,413,100.69
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,000,000,000.00	98,723,938.00		824,903,736.85	3,923,627,674.85
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				-16,025,495.45	-16,025,495.45
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,000,000,000.00	98,723,938.00		808,878,241.40	3,907,602,179.40
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт			26,624,000.00		26,624,000.00
Зарласан ногдол ашиг				-103,300,420.00	-103,300,420.00
Бусад дэлгэрэнгүй орлого				2,902,496.87	2,902,496.87
Тайлант үеийн үр дүн				2,244,867,696.91	2,244,867,696.91
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,000,000,000.00	98,723,938.00	26,624,000.00	2,953,348,015.18	6,078,695,953.18

3.4 Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан.
/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх он	Тайлант он
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	357,841,481,316.41	421,655,426,439.75
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	688,415,966.28	1,934,247,371.49
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	18,995,086.00	10,383,439.00
Татаас санхүүжилтийн орлого	1,000,000,000.00	
Бусад мөнгөн орлого	356,134,070,264.13	419,710,795,629.26
Мөнгөн зарлагын дүн (-)	357,261,154,755.12	420,107,016,121.89
Ажилчидад төлсөн	512,129,757.56	588,589,018.52
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	123,435,138.19	154,793,617.90
Бараа материал худалдан авахад төлсөн	18,441,989.00	14,080,725.00
Ашиглалтын зардалд төлсөн	30,481,093.58	261,941,422.52
Түлш шатахуун тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд	3,746,100.00	4,704,397.00
Хүүний төлбөрт төлсөн	-	10,700.00
Татварын байгууллагад төлсөн	94,212,869.44	176,880,140.04
Даатгалын төлбөрт төлсөн	350,200.00	
Бусад мөнгөн зарлага	356,478,357,607.35	418,906,016,100.91
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	580,326,561.29	1,548,410,317.86
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	7,033,234,678.80	10,648,705,878.28
Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	6,221,631,516.70	9,754,895,920.00
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		16733090.98
Хүлээн авсан хүүний орлого	811,603,162.10	877076867.30
Мөнгөн зарлагын дүн (-)	17,895,547,743.98	10,549,043,206.72
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	165,367,075.00	17,764,439.60
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	17,730,180,668.98	10,500,088,767.12
Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		31,190,000.00
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	-10,862,313,065.18	99,662,671.56
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	-	-
Мөнгөн зарлагын дүн (-)	459,908.61	89,827,909.52
Төлсөн ногдол ашиг	-	89,895,240.00
Валютын ханшиний алдагдал	459,908.61	-67,330.48
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	-459,908.61	-89,827,909.52
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-10,282,446,412.50	1,558,245,079.90
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	10,870,842,876.86	588,396,464.36
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	588,396,464.36	2,146,641,544.26

3.5 Аудит хийсэн 2018 оны эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшин, төлөвлөгөөний биелэлт

4.5.1. Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин

/мянган төгрөгөөр/

Д/ Д	Эдийн засгийн үндсэн үзүүлэлт	2017 он		2018 он		2018 Биелэлт	
		Төлөвлөгө ө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
		А	Д	Е	Ж	З	К=(Ж-З)
1	Үнэт цаасны хадгаламжийн үйлчилгээний орлого	251,134.3	370,851.5	343,240.0	401,008.9	57,768.9	116.8
2	Үнэт цаасны өмчлөх эрх бүртгэлийн орлого	294,043.2	297,699.1	510,555.3	1,417,158.0	906,602.7	277.5
3	Кастодианы үйлчилгээний орлого	6,000.0	6,000.0	6,000.0	6,397.4	397.4	106.6
4	Бусад орлого	18,850.0	19,724.4	65,839.2	108,810.9	42,971.7	165.3
5	Үйл ажиллагааны бус орлого	141,858.5	1,245,411.9	1,714,077.0	1,784,951.6	70,874.6	104.1
6	Нийт орлого	711,885.9	1,939,686.9	2,639,711.5	3,718,326.7	1,078,615.2	140.8
7	Нийт зардал	1,064,541.9	1,028,056.7	1,399,547.2	1,286,172.2	(113,375.0)	91.9
	Үүнээс: Удирдлагын зардал	66,584.2	65,533.7	83,460.1	83,415.5	(44.7)	99.9
8	Татварын өмнөх ашиг /алдагдал/	647,344.1	911,630.2	1,240,164.3	2,432,154.5	1,191,990.2	196.1
9	Цэвэр ашиг /алдагдал/	620,310.2	897,413.1	1,137,918.7	2,244,867.7	1,106,949.0	197.3
10	Төрийн өмчийн ногдол ашиг		89,895,240.0			-	
11	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	0.62	0.52	0.53	0.35	(0.18)	65.2
12	Нийт авлага	142,659.8	173,699.4	61,331.6	85,110.0	23,778.4	138.8
13	Нийт өр төлбөр	21,500.0	10,044.5	13,057.8	11,264.0	(1,793.8)	86.3
	Богино хугацаат өр төлбөр	21,500.0	10,044.5	13,057.8	11,264.0	(1,793.8)	86.3
14	Их засвар, Хөрөнгө оруулалт	22,037.0	165,367.1	90,880.0	66,311.0	(24,569.0)	72.9
15	Ажиллагсад	39	37	40	37	(3)	92.5
16	Цалингийн сан	622,896.0	570,187.1	626,712.0	626,043.5	(668.5)	99.9

4.5.2. Зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

№	Зардлын төрлүүд	2016 он	2017 он	2018 он	2018 он	Харьцуулалт	
		Гүйцэтгэл	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	А	Б	Б	Г	Д	Е=(Д-Г)	Е=(Д/Г)
1	Цахилгааны зардал	5,923.5	8,371.2	11,400.0	8,987.9	(2,412.1)	79%
2	Дулааны зардал	394.8	1,464.6	1,610.0	1,974.5	364.5	123%
3	Усны зардал	324.4	713.7	780.0	587.7	(192.3)	75%
4	Сэлбэг хэрэгсэл, даатгал	1,775.1	1,457.8	5,155.0	5,155.0	-	100%
5	Гражийн түрээс	1,611.9	2,485.3	4,440.0	4,122.5	(317.5)	93%
6	Урсгал засвар	692.0	11,428.9	11,000.0	10,167.6	(832.4)	92%
7	Хангамжийн материал	12,899.3	10,987.3	7,000.0	11,447.5	4,447.5	164%
8	Үндсэн ба нэмэгдэл цалин	23,461.3	514,073.7	626,712.0	626,043.5	(668.5)	100%
9	Байгууллагаас төлөх ЭМ, НДШ	37,676.3	56,113.4	85,503.4	75,613.8	(9,889.6)	88%
10	Нэг удаагийн тэтгэмж /тэтгэвэрт/		-	7,984.4	7,444.4	(540.0)	93%
11	Албан томилолтын зардал	69,882.8	46,890.6	50,000.0	50,644.6	644.6	101%
12	Харилцаа холбооны зардал	280.9	11,984.1	14,958.4	13,698.4	(1,260.0)	92%
13	Серверийн үйлчилгээний зардал	27,112.2	39,614.5	51,996.0	51,128.1	(867.9)	98%
14	Технологийн хөгжүүлэлтийн зардал		-	122,900.0	-	(122,900.0)	0%
15	Гүйцэтгэх удирдлагын зардал		65,533.7	83,460.1	83,415.4	(44.7)	100%
16	ТУЗөвлөлийн зардал	29.7	45,932.8	51,000.0	45,856.0	(5,144.0)	90%
17	Борлуулалт, маркетингийн зардал	0.2	7,591.6	13,000.0	12,546.1	(453.9)	97%
18	Сургалтын зардал	12.4	7,471.8	14,820.0	6,169.8	(8,650.2)	42%
19	Зохицуулалтын үйлчилгээний хөлс	39.2	32,875.0	28,120.3	68,146.5	40,026.2	242%
20	Үйл ажиллагааны бусад зардал	11.6	28,648.5	40,000.0	33,431.1	(6,568.9)	84%
	Үйл ажиллагааны зардал	182,127.5	893,638.5	1,231,839.6	1,116,580.4	(115,259.2)	91%
21	Элэгдлийн зардал	46,610.6	102,355.4	118,336.0	122,423.5	4,087.5	103%
	Бусад татварын зардал	9,290.0	19,092.6	17,431.6	15,588.3	(1,843.3)	89%
	БОШХ	238,028.1	1,015,086.5	1,367,607.2	1,254,592.2	(113,015.0)	92%
26	Бусад зардал	11,824.6	12,970.2	23,800.0	23,450.0	(350.0)	99%
27	Урьдчилан сэргийлэх үзлэг		-	8,140.0	8,130.0	(10.0)	100%
	Үйл ажиллагааны бус зардал	11,824.6	12,970.2	31,940.0	31,580.0	(360.0)	99%
	Нийт зардлын дүн	249,852.7	1,028,056.7	1,399,547.2	1,286,172.2	(113,375.0)	92%

АУДИТЫГ ЯВЦАД ИЛЭРСЭН АЛДАА ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ

Огноо:
2019.03.10

Аудитын
нэр

Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв
ХХК-ийн
2018 оны Санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код

САГ/2019/62/СТА-ТӨҮГ

Шалгагдсан
байгууллагын нэр:

Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК

Мянган төгрөгөөр

No	Алдаа зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгуул агаас гаргасан шийдэл	Алдаа зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
A	3	4	5	8	9
1	Үнэт цаас өмчлөгч, харилцагчдын харилцах дансан дахь мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг хадгаламжинд байршуулж хүүгийн орлого олж байгаа нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.7, 45.8 дахь заалт болон санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг батламж мэдэгдэлд нийцээгүй.		Зөвлөмж өгсөн.	Өмнөх гүйцэтгэх Захирал	Ш.Лхагва
2	Компанийн дотоод журмын 7.1.1-д "...ажилтанд.. Захирлуудын Зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн ...нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд нь зориулж компанийн зүгээс хүүгүй зээл олгож болно" гэж заасан нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 3 дахь заалтыг зөрчсөн байна. Дотоод журмын энэ заалтыг үндэслэн 2018 онд 3 ажилтанд 22,000.0 мянган төгрөгийн зээл олгосон.	22,000.0	Зөвлөмж өгсөн.	Өмнөх гүйцэтгэх Захирал	Ш.Лхагва

3	<p>Ажилтан өндөр насны тэтгэвэрт гарах үед ТУЗ-ийн шийдвэргүйгээр гүйцэтгэх захирал тушаал гаргаж 7,964.0 мянган төгрөгийн буцалтгүй тусламж олгосон. Энэ нь компанийн дотоод журмын 7.1.10-д “...ажилтан нь ...өндөр настны тэтгэвэр тогтоолгоход нэг удаагийн мөнгөн тэтгэмж олгох асуудлыг Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулан шийдвэрлүүлнэ” гэж заасныг зөрчсөн.</p>	7,964.0	Зөвлөмж өгсөн.	Өмнөх гүйцэтгэх Захирал	Ш.Лхагва
	Дүн	29,964,0			

